Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | | |
| 1.1 | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг тооцож ажиллах | - | Хэрэгжилтийн хувь | 96.4 хувь | 70.0 хувь | - | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Орхон аймгийн Засаг даргатай хамтран ажиллах “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний хэрэгжилт эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 72.0 | 70 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 1.2 | Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож ажиллах | | Хэрэгжилтийн хувь | 96.2 хувь | 70.0 хувь | - | Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 28 зорилт, 124 заалттайгаар хэрэгжүүлэхээр Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна. | 70% |
| 1.3 | Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт тавих | ОНТ 300 сая | Үр дүнгийн үзүүлэлт | Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжсэн байна. | 30 % | - | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 13/05 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийг, аймгийн Засаг даргын 2023 оны А/811 дүгээр захирамжаар тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийн ажиллах журмыг баталсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ажлын хэсэгт Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь Салбар зөвлөлийн 2 гишүүн ажиллаж байгаа бөгөөд 1 гишүүн өндөр насны тэтвэгэрт гарч албан тушаалаасаа чөлөөлгдсөн тул АЗДТГ- | 60 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ын ХЭЗХ-ийн мэргэжилтэн аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон .<br>“Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 300.0 сая төгрөг шийдвэрлэсэн бөгөөд тус Ажлын хэсгийн 2 удаагийн хурлыг зохион байгуулсан.<br>Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэхэд төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар баталуулан төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах Ажлын хэсгийн 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу төрийн байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан Бүсийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оношилгоо, эмчилгээний төвийн Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал М.Алтанбек нь Солонгос Улсын Дэгү хотын Кеймюнь их сургуулийн Донан эмнэлэгт 1 сарын хугацаанд үе солих мэс заслын дараах хүндрэлийг эргэн засах чиглэлээр суралцах сургалтын зардалд шаардагдах 7.1 сая төгрөгийн дэмжлэгийг шийдвэрлүүлсэн | |
| 1.4 | Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | ОНТ 200 сая | Хэрэгжилтийн хувь | 90.0 хувь | 50.0 хувь | - | Багийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2025 онд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Үүнд:<br>Орон нутгийн төсвийн 91.6 сая төгрөгөөр 14 багийн байранд урсгал засвар, 29.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар багуудыг техник тоног төхөөрөмж, шаардлагатай эд хогшлуудаар хангасан.<br>Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх ажлыг сайжруулахад зориулж орон нутгийн төсвөөс нийт 32.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Багийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь сургалтуудыг 6 удаа зохион байгуулж, багийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор багийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, буцалтгүй тусламж олгох, иж бүрэн гэр олгох, бичгийн хэрэгсэл, албаны жигд хувцсаар хангахад орон нутгийн төсвөөс 116.4 сая төгрөг зарцуулсан.<br>Иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах irgen.erdenet.mn вэб системд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх "Иргэний цахим булан"-гийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд орон нутгийн төсвийн 16.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Багийн үйл ажиллагааг сурталчлах, иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор нийт багууд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношлогоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна. | |
| 1.6 | Гадаад үйл ажиллагаатай холбоотой албан бичиг, баримтуудын төслийг боловсруулах, орчуулах | | Гадаад харилцааны сайдын 2017 оны А/73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.1 дэх заалтын дагуу | Гадаад үйл ажиллагаатай холбоотой 1 албан бичиг боловсруулан орчуулагдан төрийн захиргааны төв байгууллагаар | 70% | | Хамтын ажиллагаат улс орнуудад урилга, албан тоот, хөтөлбөрийг орчуулан хүргүүлсэн. | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хянагдсан байна. | | - | | |
| 1.7 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг аль болох богино хугацаанд /хуулинд заасан хугацаанд багтаан/ шийдвэрлэж хариу өгөх | УТ, ОНТ | 9.6 | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 9.5 өдөр болгоно. | | | Тайлангийн хугацаанд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 2767 өргөдөл, гомдол ирсний 156 буюу 5.6 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 2611 буюу 94.4 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн өргөдөл, гомдлын 72 нь гомдол, 65 нь талархал,8 нь санал, 2622 нь хүсэлт байна. Ирсэн нийт өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд орлогод нийцсэн орон сууц хүссэн 38.8 хувь, газрын харилцааны асуудлаар 8.4 хувь, нийгмийн халамжийн төрөл бүрийн үйлчилгээ авахыг хүссэн 6.8 хувь, халаалт цэвэр бохир ус шугам хоолойтой холбогдолтой асуудлаар 6.7 хувь, барилгын асуудлаар 3.6 хувь, нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 3.1 хувь, нийтийн | 80 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тээврийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.8 хувь, боловсролын салбарын үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.1 хувь, нийгмийн даатгалын салбарын асуудлаар 1.9 хувь, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 1.8 хувь эдгээр өргөдлүүд нийт өргөдлийн 76.0 хувийг эзэлж байна.Үүнээс: Аймгийн ЗДТГ-т тус төвд нийт 776 өргөдөл, гомдол ирснээс 100 хувь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн. Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.Аймгийн ЗДТГ-т ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9.5 хоног байна. | |
| 1.8 | Арга хэмжээ 1.6 Албан томилолтоор гадаад улсад ажиллах албан хаагчдын | | | | 2024 онд 5 албан хаагч албан | - | 13 удаагийн гадаад томилолтын удирдамж, ярианы сэдэв, хөтөлбөр | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | явах бэлтгэл ажлыг хангах /тухайн ажиллах улсад ажиллах үеийн удирдамж, хөтөлбөр гарган батлуулах, зорчих тасалбар захиалах гэх мэт/ | | | | томилолтоор ажилласан | | боловсруулан, тасалбар захиалга хийж ажиллаа. | |
| 1.9 | Орон нутагт гадаад дотоодын аялал жуулчлалыг татах зорилгоор улс, бүсийн чанартай соёл, урлагийн арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах | | | Тоо | 2024 онд 2 арга хэмжээ зохион байгуулагдсан. | - | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын бага, дунд боловсролын байгууллага хамтын ажиллагааны хүрээнд хоёр орны ЕБС алсын зайн соёл урлагийн арга хэмжээг зохион байгууллаа. байна. | |
| **2.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| 2.1 | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, шударга, ил тод, соёлтой болгоно. | ОНТ | Төрийн үйлчилгээний төв үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байх | Холбогдох хууль тогтоомжийг мөрдсөн | 33 байгууллага Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан байна. | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, цахим үйлчилгээний тоо нэмэгдэнэ. Төрийн үйлчилгээнд операторын үйлчилгээ нэвтэрнэ | Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр, Цахим Эрдэнэт хөтөлбөрт тусгагдсаны дагуу Баян-Өндөр, Жаргалант сумын E-mongolia төв иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна . Энэхүү төвийн үйл ажиллагаа нь төрийн үйлчилгээг цахимаар авахад шаардлагатай мэдээлэл, арга зүйн зөвлөгөөг иргэдэд өгөх, E-mongolia аппликейшн гар утсандаа татах, E-mongolia порталаас хэрхэн төрийн | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлчилгээг өөрсдөө авах арга зүйн зөвлөгөөг өгч, төрийн мэдээллийн Хур системийг ашиглан иргэд, байгууллагуудад төрийн байгууллагын 236 төрлийн лавлагаа тодорхойлолтуудыг гарган өгч үйлчилгээ үзүүлж байна. Цахимжилт хэрхэн явагдаж байгаа талаар танилцуулга уулзалтыг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын дунд зохион байгуулж Хөдөлмөр халамжийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Татварын хэлтсээс үзүүлж буй үйлчилгээнүүдийг хэрхэн цахимжуулах талаар туршлага солилцсон. Мөн E gazar.gov.mn цахим систем ашиглалтад орсноор газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас үзүүлдэг 76 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төрлийн үйлчилгээг цахимжуулсан.<br>Төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим үндэстэн болох чиглэлээр Засгийн газраас томоохон зорилтууд дэвшүүлээд ажиллаж байгаа бөгөөд манай аймаг цахимжуулалтын ажлыг түүчээлэн ажиллаж байна. 2025 онд Орхон аймгийн Баян-Өндөр суманд шинээр И-Монголиа төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр нийт 113 төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 41883 ширхэг лавлагаа тодорхойлолт, тусгай зөвшөөрөл зэргийг гаргаж иргэдэд Тараах материал гарын авлага тогтмол өгч ажиллаж байна.Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 80-90 хувьд И-Монголиа аппликейшн суулгаж, бүртгэл үүсгэж, төвийн 70351000, 70396000 лавлах дугаарт ирсэн дуудлага бүрд зөвлөгөө | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээлэл өгч ажиллаж байна | |
| 2.1 | Мэдээллийн технологийг сайжруулах, цахимжуулах, Тамгын газрын сүлжээний хэвийн ажиллагааг хангах. | ОНТ | Орон нутгийн төсөв | Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах | Мэдээллийн санд хандах, мэдээлэл олж авах цаг хугацаанд хэмнэлт гарсан | | Байгууллагын давхар бүрд, дотоод болон гадаад сүлжээний гол гол зангилаанууд дээр managed cisco router-үүдийг байрлуулж сүлжээний доголдол үүсэхээс бүрэн сэргийлж ажиллаж байна. Интернэтийн тасралтгүй найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор "Юнившин" ХХК болон "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-уудын үйлчилгээг ашиглан интернэтийн давхар гарцыг бий болгон үйл ажиллагаандаа ашиглаж байна. Дотоод сүлжээний бүх зангилаа | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дээрх төхөөрөмжүүдийг шинэчилж дотоод сүлжээний урсгал 100mbps байсныг өргөжүүлж 1000mbps болгон хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Ингэснээр дотоод болон гадаад сүлжээний мэдээллийн урсгал сайжирсан. | |
| 2.2 | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх дундаж хугацааг өнөөгийн түвшнээс бууруулах | Санхүү жилт шаард ахгүй | Дундаж хугацааг бууруулсан байх | Дундаж хугацаа 10 хоног Дундаж хугацааг бууруулсан байх | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа суурь түвшингээс буурч, богино хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа суурь түвшингээс буурч, богино хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны А/257 дугаар захирамжаар байгуулагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгээс 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс 04 дүгээр сарын 22-ны өдрийн хугацаанд аймгийн Засаг даргын дэргэдэх төрийн захиргааны байгууллагуудад 2024 онд иргэдээс Жаргалант, Баян-Өндөр сумын ЗДТГ, 28 төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний байдалтай танилцан хяналт шинжилгээ үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний явцад ирсэн өргөдөл, гомдлын | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэлтэнд тавих хяналтыг сайжруулах. www.irgen.erdenet.mn сайтын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй байгаа тул цаашид багуудын цахим булангийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулан холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаан ажиллах талаар 28 байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан ажилтанд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав. | |
| 2.3 | Аймгийн ЗДТГ-ын албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу эрхлэн хөтлөх, баримт бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллах, лавлагаа өгөх, байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх, хадгалах, ашиглуулах болон төрийн архивт шилжүүлэх | ОНТ | Холбогдох хууль тогтоомжид нийцүүлж албан хэргийг хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавина. | Холбогдох хууль тогтоомжид нийцүүлж албан хэргийг хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавина. | | Архивын баримт бичгүүд хууль тогтоомжийн дагуу хадгалагдана. Тамгын газрын дотоод хэргийн эрхлэлтэд ахиц гарна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Монгол хэлний зөв бичих дүрмийн журмалсан толь, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам, 2021 оны Баримт бичгийн стандарт /MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140- | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3:2021/-ын дагуу аймгийн ЗДТГ-ын албан хэргийг хөтөлж байна.<br>100 хувь<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар 1835 ирсэн бичгийг И-Оффис программд бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавив. 1761 явсан бичгийг стандартын дагуу хэвлэн 4484 байгууллагуудад цахимаар болон цаасаар хүргүүлэв.<br><br>Баримт бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гарган танилцуулж, хугацаатай ирсэн 75 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаанд нь хүргүүлэн ажиллав. Аймгийн ЗДТГ-ын Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх хадгаламжийн нэгжийн жагсаалтын дагуу 2017-2019 он хүртэлх 442 ширхэг баримтуудыг цахимжуулахаас 209 баримтыг цахимжуулаад байна. Байгууллагад хадгалах хугацаа дууссан 909 хадагламжийн нэгжийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахим хувийн хамт Төрийн архивт хүргүүлэв. 50 хувьтай явж байна. | |
| 2.4 | Төрийн албан хаагчдад программ хангамжийн арга зүйн зөвлөгөө өгөх. | ОНТ | Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах | Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд ад ажиллаж буй ажиллах хүчний мэдээллийн сан бүрдүүлэх | Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах | Холбогдох хууль тогтоомжи йг мөрдөн ажиллах | Систем ашиглагч байгууллага, хэлтэс нэгжүүдийн мэргэжилтэн ажилтнуудад мэргэжил арга зүйн туслалцааг утсаар, цахимаар, биечлэн тогтмол өгч ажиллаж байна. Тайлант хугацаанд И-Оффис системд 154 байгууллага 1712 хэрэглэгч холбогдон өмнөх онтой харьцуулахад байгууллага 0.4 хувиар , хэрэглэгч 0.9 хувиар нэмэгдсэн байна. Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. Тайлант хугацаанд 6 компьютер, 4 принтерийг албан хаагчдад сольж суурилуулан зөвлөгөө өгч ажилласан байна | 100 % |
| 2.5 | Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулахад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах | ОНТ | Тоног төхөөрөмж хэвийн ажиллаж байх | Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах | Холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм, журамыг мөрдөн ажиллах | | Ерөнхий шалгалт 10, тусгай шалгалт 53 удаа /өссөн дүнгээр/ | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| 3 | Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн болон зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангаж зохион байгуулж ажиллах | - | Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. | 2024 онд 52 удаа хуралдсан | Аймгийн засаг даргын шуурхай зөвлөгөөн төлөвлөгөөний дагуу хуралдаж тодорхой үүрэг даалгаваруудад хэрэгжсэн байх. | 2025 оны эхний хагас жилд 23 удаа Төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж холбогдох байгууллагуудад нийт 163 үүрэг даалгавар өгөгдөж 94.5 % биелэлттэй байна. | Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. | 100 % |
| 3.1 | Аймгийн Засаг даргын захирамжийг албажуулан бүртгэх, хадгалах | - | Холбогдох дүрэм зааврын хэрэгжилтээр | Нийт 800 гаруй захирамжийг Шилэн дансанд хугацаанд нь байршуулж ажилласан | Холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, хугацаанд нь байршуулах | Холбогдох журам, зааврын дагуу бүртгэлжүүлж хадгална | 2025 оны 06 сарын 06-ны өдрийн байдлаар аймгийн Засаг даргын зохион байгуулалтын 473, хүний нөөцийн 12 захирамжийг холбогдох журмын дагуу албажуулан бүртгэсэн. | 100 % |
| 3.2 | Шагналын асуудлыг хариуцан зохион байгуулах /төрийн дээд болон аймгийн Засаг даргын нэрэмжит шагнал | ОНТ | Холбогдох дүрэм, журмын хэрэгжилт | Холбогдох хууль дүрэм, шагналын журмыг | Холбогдох хууль дүрэм, шагналын журмыг | Холбогдох хууль дүрэм, шагналын журмыг | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мөрдөж ажилласан | мөрдөж ажиллах | мөрдөж ажиллах | өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам болон Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын журмын дагуу шагналд тодорхойлогдсон 370 гаруй иргэдийн материалыг хүлээн авч судлан, 80 иргэнийг Орхон аймгийн Хүндэт тэмдгээр, 287 иргэнийг аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнаж урамшуулсан. Аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Төрийн дээд цол, одон, медаль, алдарт эхийн одонгоор шагнуулахаар ирүүлсэн 350 иргэдийн материалыг судалж, холбогдох дээд шатны байгууллагад нь уламжлан, Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар алдарт эхийн I II дугаар зэргийн одонгоор 296 эх, Монгол улсын төрийн дээд шагналаар 210 иргэд шагнагдсан Мөн хаясан гэсэн 8 иргэний одон медалийн хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлүүлэв . | |
| 3.3 | Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, сумдууд, засаг | Санхүү жилт | Холбогдох хууль тогтоомж, Төрийн | Засаг даргын дэргэдэх | Захиргааны удирдлагаар | | Сумдын Засаг даргын үйл ажиллагааны | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | захиргааны доод шатны нэгжийг захиргааны удирдлагаар хангах | шаард ахгүй | албаны стандарт мөрдөгдөж байх | агентлаг, сумдуудыг захиргааны удирдлагаар хангах, захиргааны стандартыг хангуулах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлж ажилласан. | хангах ажилд ахиц гарна | | хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байгаа ба Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багуудыг зөвлөгөө дэмжлэг, захиргааны удирдлагаар хангаж ажиллаж байна. Засаг даргын шуурхай зөвлөгөөнд оролцдог 60 байгууллагын удирдлагыг тогтмол холбогдох мэдээ мэдээллээр хангаж, холбогдох хурал зөвлөгөөнд оролцуулан ажиллаж байна | |
| 3.4 | Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр урт богино хугацааны сургалтад хамруулах | ОНТ-20 сая | Нийт төрийн албан хаагчдын 60 хувийг хамруулсан байх | 6 удаагийн сургалтанд 1800 төрийн албан хаагчдыг хамруулсан. | Төрийн албан хаагчдын 30 хувь хамрагдсан байх | Төрийн албан хаагчдын 50 хувь хамрагдсан байх | Удирдлагын академийн орон нутгийн менежерийн үүрэг гүйцэтгэж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран “Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах нь” богино хугацааны сургалтад Сургагч багш бэлтгэх сургалтад 2 байгууллагын 3, нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 5 | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын 5, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6 байгууллагын 6 , дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 7 байгууллагын 7 төрийн албан хаагч, цаашид ажиллах ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 4 байгууллагын 4 төрийн албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийг мэргэшүүлэх орон нутгийн захиалгат сургалтад 3 байгууллагын 50 албан хаагчийг тус тус хамруулж, суралцах явцад хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн Баг/хорооны засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны зорилтот танхимын сургалтад 29 багийн Засаг дарга нарыг 100 хувь хамруулсан. | |
| 3.5 | Төрийн албаны ажилтны манлайлал, ёс зүйг дээшлүүлэх, ажлын хариуцлага, дэг журмыг | Санхүү жилт шаард ахгүй | Тодорхой ажил төлөвлөн хэрэгжүүлсэн байх | Төрийн албаны ажилтны манлайлал, ёс | Төрийн албан хаагчдын үйл | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чангатгах асуудлаар зохион байгуулалтын арга хэмжээ авах | | | зүйг дээшлүүлэх, ажлын хариуцлага, дэг журмыг чангатгах ажлыг зохион байгуулсан. | ажиллагаатай холбоотой гомдол буурсан байна. | | 13.2-т заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг өгч арга зүйн удирдлагаар ханган 65 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 267 албан хаагчид томилогдон ажиллаж байна.<br>Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Бүсчилсэн зөвлөгөөн зохион байгуулах тухай" 43 дугаар тушаалаар Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг чанаржуулах зорилготой "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд Орхон аймагт хийж Орхон, Булган, Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчдыг | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцуулахаар шийдвэрлэсэн.<br>“Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” салбар хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангах чиг үүргийн дагуу аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга бөгөөд салбар зөвлөлийн гишүүн Б.Батцэцэг, АЗДТГ-ын Ёс зүйн дэд хорооны дарга О.Санжмятаваар ахлуулсан ажлын хэсэгт 15 албан хаагч ажиллаж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдаж бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган, 04 дүгээр сарын 01-06-ны өдрүүдэд хэлэлцүүлгийн байр, хэлэлцүүлэгт шаардлагатай техник хэрэгслийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажилласан.<br>Хэлэлцүүлэг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр 09 цагт Орхон аймгийн Залуучуудын ордны танхимд эхлэв. Хэлэлцүүлэгт Хойд бүсийн Орхон аймгийн 29 , Булган аймгийн 40, Хөвсгөл аймгийн 31 төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын төлөөлөл болох 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрийн албан хаагч болон Ёс зүйн хорооны дарга, ажлын албаны хамт олон оролцов. Төрийн захиргааны албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн асуудлаар гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | |
| 3.6 | Сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс бүрдүүлэх, тусгай шалгалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | ОНТ | Холбогдох хууль тогтоомжид нийцүүлж зохион байгуулсан байна | | Хүний нөөцийн бодлого төлөвлөлт хэрэгжиж, мэргэшсэн албан хаагчдаар хангагдах ба ТА-ны шударга ил тод байдал хангагдсан байна. | | 2025 оны эхний хагас жилд төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг 21 байгууллагын 30 сул албан тушаалын захиалгыг хүлээн авч, холбогдох хууль, эрх зүйт нийцэж байгаад үнэлгээ хийн, төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах зарыг 11 удаа нийтэд мэдээлсэнээс төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа 5 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон. Шилжүүлэх зараар нөхөгдөөгүй 25 сул орон тооны захиалгыг | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төрийн албаны зөвлөлд 7 удаа хүргүүлсэн бөгөөд дэс түшмэлийн 26 албан тушаалд 3, ахлах түшмэлийн 2 албан тушаалд-1 удаа, төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч 2 албан тушаалд 1 удаа нийт 5 удаа Салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан комисс тусгай шалгалтыг зохион байгуулахад 16 төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэд тэнцсэн. Төрийн албаны салбар зөвлөлөөс тэнцсэн 16 оролцогчыг нэр дэвшүүлэн тухайн байгууллагуудад томилсон болно. Тайлант хугацаанд 16 сул орон тооноос 61.5 хувь нь нөхөгдсөн .<br>Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу 11 удаа 21 байгууллагын 30 албан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалд шилжих зарыг нийтэд зарласнаас төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа 5 төрийн жинхэнэ албан хаагчдыг шилжүүлэн томилсон.<br>Хотын захирагчийн албаны Инженерийн байгууламж, шугам сүжээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Төсөвчин, Эрүүл мэндийн газрын Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт, осол гэмтлын тандалт хариуцсан мэргэжилтэн, Амьсгалын зам, сүрьеэгийн халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн, Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, амны хөндийн эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн, Бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдлын вирусын өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн, Эх барих эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ хариуцсан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжилтэн, Боловсрол шинжлэх ухааны газрын Математик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйчийн сул орон тоог зарласан бөгөөд оролцогч материалаа илгээгүй тул тухайн албан тушаалууд нөхөгдөөгүй байна.<br>Тусгай шалгалтуудын бүртгэл, зохион байгуулалтай холбоотой гомдол санал гараагүй бөгөөд тайланг хуулийн хугацаанд Төрийн албаны зөвлөлд тухай бүр нь хүргүүлсэн.<br>Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт тусгай шалгалтын зар тавигдсаны дараа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, цахимаар бүртгүүлэх зөвлөмжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч аймгийн ЗДТГ-ын цахим хуудас болон мэдээллийн самбар, тухайн байгууллагын цахим хуудасанд байршуулж нийтэд мэдээлж хэвшсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, сонирхсон этгээд шалгалтын үйл явцыг дэлгэцээр ажиглан харах, түүнчлэн шалгалтын үйл явцыг Төрийн албаны зөвлөлөөс хянах боломжийг хангаг ажилласан | |
| 3.7 | Ерөнхий шалгалтыг нутаг дэвсгэрийн хүрээнд улирал бүр зохион байгуулах | | | Шалгалт зохион байгуулсан тоо | 50 % | 50 % | Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт Ерөнхий шалгалтын зар тавигдсаны дараа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журмын дэлгэрэнгүй мэдээлэл өгч, аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлж хэвшсэн.<br>Мөн шалгалтын товыг аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас www.erdenet.mn сайтад болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлсэн.<br>Ерөнхий шалгалтад бүртгүүлэх иргэдэд цахим бүртгэлд | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүртгүүлэх талаар зөвлөмж бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас www.erdenet.mn сайтад болон мэдээллийн самбарт байршуулж нийтэд мэдээлсэн.<br>Төрийн албаны цахим бүртгэлтэй холбоотой 23 хүсэлтийг утсаар болон биеэр хүлээн авч тухай бүр зөвлөмж өгч бүртгүүлсэн..<br>Тухайн улиралын ерөнхий шалгалт зохион байгуулахтай холбоотой Салбар зөвлөлийн даргаар Ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл, зохион байгуулалтын 8 зохион байгуулах үе шат 33 заалт бүхий хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг албан тушаалтан, хугацааг нарийвчлан гарган батлуулж хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь биелсэн.<br>Орхон аймаг дахь ТАЗСЗ-ийн албан бичгээр Ерөнхий | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгалт зохион байгуулах үед хамтран ажиллах талаар аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Тагнуулийн Ерөнхий газрын харъяа Орхон аймаг дахь Тагнуулийн газар, Цахилгаан дамжуулах Үндэсний төв, Онцгой байдлын газар, Бусийн оношилгоо эмчилгээний төв, “Эрдэнэт-Ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-д мэдэгдэн хамтран ажилласан.<br>2024 оны 1, 2 дугаар улиралд ерөнхий шалгалт зохион байгуулахад 193 иргэн шалгалтад оролцохоор бүртгүүлсэнээс 157 иргэн буюу 81.3 хувь нь шалгалтад оролцож байсан бол 2025 оны 1, 2 дугаар улиралд ерөнхий шалгалт зохион байгуулахад 162 иргэн шалгалтад оролцохоор бүртгүүлсэнээс 113 иргэн буюу 69.7 хувь нь шалгалтад оролцсон нь өмнөх жилийн мөн үеэс бүртгүүлсэн иргэдийн тоо 18.7 хувиар, шалгалт өгсөн иргэдийн тоо 11.6 хувиар буурсан нь ерөнхий шалгалтад | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүртгүүлэх иргэдийн тоо болон бүтгүүлсэн иргэд ясар нэг шалтгаан зааж шалгалтандаа оролцох сонирхол буурч байна.<br>Харин 2024 оны 1, 2 дугаар улиралд ерөнхий шалгалт зохион байгуулахад шалгалт өгсөн иргэдийн 51 иргэн буюу 32.4 хувь нь тэнцэж байсан бол 2025 оны эхний 2 улиралд 54 иргэн буюу 47.7 хувь нь тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 15 хувиар нэмэгдсэн.<br>Ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл Ажлын хүрээнд ерөнхий шалгалтад бүртгүүлсэн иргэдэд “Бат гэгээн эрдэм” ТББ -тай хамтран 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Тухайн сургалтад хамрагдсан иргэдийн хүсэлтээр 06:00-22:00 цаг хүртэл сургалтыг хийсэн. ТАСЗ-өөс тухайн сургалтыг зохион байгуулах байраар хангаж өгсөн бөгөөд тухайн сургалтад хамрагдсан 13 иргэний 92.3 хувь ерөнхий шалгалтандаа тэнцсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төрийн албан хаагчдын сургалтын танхимд 2025 оны 1, 2 дугаар улирлын Ерөнхий шалгалтыг зохион байгуулсан. | |
| 3.8 | Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах, салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах | | Хуралдааны тоо | Гүйцэтгэлээр | | | Тайланд хугацаанд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлаарх нутгийн захиргааны байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны санал, танилцуулгыг төрийн захиргааны 26 байгууллагын 114 төрийн захиргааны албан хаагчийн материалыг хүлээн авч судлан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар 2 удаа хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүлээсэн үүргээ "Хангалттай сайн" биелүүлсэн нийт ахлах түшмэл 9, дэс түшмэл 74, туслах түшмэл 13 бүгд 95 төрийн жинхэнэ албан хаагчдад төрийн захиргааны албан | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалын зэрэг дэв олгох болон ахиулах ажлыг зохион байгуулсан | |
| 3.9 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах | ОНТ | | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах талаар 2019 оны төлөвлөгөөг биелүүлж ажилласан. | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаанд ахиц гарсан байна. | | Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж дууссан. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн дагуу судалгааг хагас бүтэн жилээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллаж байна.<br>Үүнд:<br>1. 2025 оны эхний 11 сарын байдлаар (давхардсан тоогоор) 48 албан хаагч томилолтоор ажилласан байна. Томилолтын зардалд 39,428,800 (гучин есөн сая дөрвөн зуун хорин найман мянга найман зуу) төгрөгийг зарцуулж, хувиас гаргасан зардлыг нөхөн олгосон байна.<br>2. Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад төрийн | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан хаагчдад дараах тусламж, дэмжлэгийг олгосон байна. Үүнд:<br>1. Албан хаагчдын дархлааг дэмжих ажлыг зохион байгуулж, эхний хагас жилд 71 албан хаагчид 4,260,000 (дөрвөн сая хоёр зуун жаран мянга) төгрөг, сүүлийн хагас жилд 71 албан хаагчид 9,017,000 (есөн сая арван долоон мянга) төгрөг буюу нийт 13,277,000 (арван гурван сая хоёр зуун далан долоон мянга) төгрөгийн витамин, амин дэмжүүлсэн.<br>2. Аймгийн ЗДТГ-ын 3 албан хаагчид 1,620,000 төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн.<br>3. гэр хороололд ердийн галалгаатай сууцанд амьдардаг албан хаагчид түлээ, нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлэн нийт 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөг олгосон зэрэг 3 зорилт 11 арга хэмжээг хэрэгжүүлж хэрэгжилтийн дундаж 96.3 хувьтай байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.10 | Төрийн байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо, цахим систем, тоон гарын үсэг болон инноваци нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | ОНТ | Засаг даргын Тамгын газар, Засаг даргын харъяа байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудыг систем ашиглалтыг нэмэгдүүлэх | И-Оффис системийн бүрэн ашиглалт 55%-тай байна. | Систем ашиглалтын гарын авлага гаргах, сургалт зохион байгуулах. | | Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглагддаг И-Оффис системд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэх техникийн тодорхойлолтыг боловсруулсан ба 2024 оны төсвийн тодотгол хийгдэхийг хүлээж байна. | 100 % |
| 3.11 | Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах. | ҮАЗ | Биелэлт (хувь) | Биелэлтийн дундаж 99.0 хувь | 50% | 90% | Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын “Сургалтын 2024 оны төлөвлөгөө”-нд 2 зорилт, 6 арга хэмжээг тусгагдсан. Удирдлагын академийн Ахлах түшмэлийн сургалтад 1, Дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 3, Чиглүүлэх богино хугацааны сургалтад 1 албан хаагч суралцаж байгаагаас Дунд хугацааны мэргэшүүлэх сургалтыг 1 албан хаагч нь төгссөн.<br>Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 төлөвлөгөөт 9 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 241 албан хаагч, "Хувь хүний хөгжил”-д чиглэсэн 3 удаагийн сургалтад 51 албан хаагч, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Менежментийн тогтолцооны дотоод аудитор бэлтгэх MNS ISO 9001:2016; MNS ISO 19011:2020 сургалтад байгууллагын 3 албан хаагч, Засгийн газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамдаас зохион байгуулсан төлөвлөгөөт сургалтад 54 албан хаагч хамрагдан суралцаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна. | |
| 3.10 | Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах. | ҮАЗ | Биелэлт (хувь) | Биелэлтийн дундаж 96.3 хувь | 50 | 90 | Албан хаагчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, тоног төхөөрөмж, гал, ус, цахилгааны аюулгүй байдлыг хангасан орчиноор хангаж ажиллаж байна. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн 8 албан хаагчийн зэрэг дэв нэмэгдсэн, 9 албан хаагчийг шагнал урамшуулалд тодорхойлон, шагнуулж байгууллагын дотоод журмын дагуу шагналын дагалдах мөнгөн урамшуулал болох 4,900,000 төгрөгийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | олгосон. Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулахаар 106.0 сая төгрөгийн тоног, төхөөрөмж, технологийн системийг худалдан авч эд хөрөнгийн картад бүртгэн хяналт тавин ажиллаж байна. Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3, 4, 10, 11, 12 дугаар хавсралтын дагуу байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоож, төрийн алба хаасан хугацааны, ур чадварын, орон нутагт ажилласны зэрэг нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу олгон ажиллаж байна. Албан хаагчдыг дахин мэргэшүүлэх, эрдмийн цол зэрэг авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | |
| 3.11 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод харилцааг зохицуулах, хөдөлмөрийн дотоод журам боловсруулах, шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох. | ҮАЗ | Хэрэгжилт (хувь) | Нийт хэрэгжилтийн дундаж 99.6 хувь | 50 | 90 | Тайлант оны эхний хагас жилийн байдлаар Хөдөлмөрийн дотоод журамд шаардлагатай 2 нэмэлт өөрчлөлтийг оруулж, аймгийн Тамгын газрын нийт албан | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаагчдад танилцуулсан. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2025 оны 06 сарын 06-ны өдрийн байдлаар албан хаагчдаас нийт 66 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнд:<br>- Хөдөлмөрийн харилцаатай холбогдох 14;<br>- Ээлжийн амралттай холбогдох 2;<br>- Сургалцах цалинтай чөлөө 2;<br>- Шагналын дагалдах мөнгөн урамшуулал 10;<br>- Цалинтай чөлөө 4;<br>- Цалингүй чөлөө 3;<br>- Ар гэрийн гачигдал (мөнгөн дэмжлэг) 7;<br>- Илүү цаг нөхөн амрах 5;<br>- Урамшуулалтай холбогдох 3;<br>Шийдвэрлээгүй 1 өргөдөл, хүсэлт байна. | |
| 3.12 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын мэдээллийн | ОНТ Төрийн албан | | Албан хаагч нарын мэдээллийн | Албан хаагч нарын мэдээллийн | | Төрийн албаны 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сан, хувийн хэрэг, too бүртгэлийг хөтлөн баяжуулах, тэдгээртэй холбогдолтой мэдээллээр удирдлагыг хангах. | хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн баяжуулж, мэдээллийг ХНУМС-тэй тулган шинэчиллээ. | | сан, хувийн хэрэг, too бүртгэлийг тухай бүр шинэчлэх | сан, хувийн хэрэг, too бүртгэлийг тухай бүр шинэчэн баяжуулсан байна. | | албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь хэлтэс, албадын ахлах мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, харьяалагдах албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлийг шинэчлэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Байгууллагад нийт 68 албан хаагч харьяалагдан ажиллаж байгаа бөгөөд хувийн хэрэг, too бүртгэлийн системийг хөтлөн явуулж байна. Төрийн албаны зөвлөлөөс 2023 онд "Хүний нөөцийн аудит" хийгдэж, ажил сайжруулах зөвлөмж авсан. Тус зөвлөмжийн дагуу ажил сайжруулах арга хэмжээ аван ажиллаж 95 хувийн гүйцэтгэлтэйгээр холбогдох газарт тайлагнасан. Үүнд: Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийн тогтолцоо" цахим системд албан хаагчийн (хувийн) үндсэн мэдээлэл, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, түүний хугацаа, цалин хөлс, мэргэжил, мэргэшил дээшлүүлсэн байдлыг мэдээлэн баяжуулалт хийн тайлагнаж, тайлант хугацаанд 68 албан хаагчийн 500 гаруй мэдээллийг нэмэлтээр оруулан, баяжуулсан. | |
| 3.13 | Албан хаагчдын цалин урамшууллыг тогтоох, зэрэг дэв олгуулах, шагнуулах, хариуцлага тооцох санал боловсруулах | ОНТ | Албан хаагч нарын үнэлгээний хуудсыг үндэслэн эрх бүхий албан тушаалтанд санал танилцуулах | Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох, шагнал урамшуулал, хариуцлагын талаар санал боловсруулсан байх | | | Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн бүтцийн нэгжүүдийн албан хаагчдын цалинг 40 хүртэл хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоож, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хагас, бүтэн жилээр гаргуулж, үнэлгээ өгөхөд бэлтгэх, мэргэшлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, удирдан чиглүүлэх, арга зүйгээр хангаж ажилласан.<br>Тайлант хугацаанд 8 албан хаагчийн зэрэг дэв нэмэгдэж, 1 албан хаагч "Алтан гадас" одонгоор, 1 албан хаагч "Засаг даргын жуух бичиг"-ээр | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шагнуулсан. 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах санал боловсруулан танилцуулсан. | |
| 3.14 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | ОНТ | Орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тоо | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын бүртгэлийг тухай бүр баяжуулж, тэдэнд дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлсэн байна. | | | Аймгийн Засаг даргын Тамгын газраас ТББ-уудтай гэрээ байгуулахад 60.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаны дагуу хэлтэс, нэгжээр хуваарь батлуулан гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар нийт 7 ТББ-тай гэрээ байгуулж 20,0 сая төгрөг зарцуулаад байна. Чиг үүргийн хувьд хэрэглэгчийн эрх ашгийн төлөө, хувь хүний хөгжил, мониторинг, сургалт мэдээлэл, нийгмийн оролцоо, хөгжил, хууль эрх зүйн мэдлэг зэрэг 5 чиг үүргийн хүрээнд хамтран ажиллаж байна.. | 100 % |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

Орхон аймгийн ЗДТГ-ын дарга ........................ / Б..ГАНЗОРИГ/

*2025.06.10*

*Тэмдэг*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* ***Нэгжийн дарга***

ХШҮ-ийн дарга ........................ / Ж.Баасансүрэн /

*2025.06.10*

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

ТЗУХ-ийн дарга ........................ /М.Жанболат/

*2025.06.10*

----------00--------